



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/176

Улаанбаатар хот

“Хатан сүйх” сууц өмчлөгчдийн холбоонд байр нэмж бүртгэж, гэрчилгээ шинээр олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 17 дугаар хорооны 31 дүгээр байрны оршин суугчдын бүх гишүүдийн 2019 оны 11 дүгээр сарын 17-ны хурлын шийдвэр, холбогдох материалыг үндэслэл болгон “Хатан сүйх” сууц өмчлөгчдийн холбоонд нэмж бүртгэж, гэрчилгээ шинээр олгох ажлыг зохион байгуулсугай.

2. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, арчлалт, хамгаалалтыг эрхлэн хариуцаж ажиллахыг “Хатан сүйх” сууц өмчлөгчдийн холбоонд үүрэг болгосугай.

3. Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд нэмж бүртгэх, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Б.Өлзийсайхан)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Хатан сүйх” сууц өмчлөгчдийн холбооны 2009 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 120 дугаар гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР